БАТЛАВ.
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ЦЭДЭВСҮРЭН

2023 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР "ЕРӨНХИЙ БОЛОВСРОГЫН СУРГУУЛИЙН СПОРТ ЗААЛАНД ТЕХНИК ХЭРЭГСЭЛ" ХУДАЛДАН АВАХАД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

| № | Тоног төхөөрөмж | Техник үзүүлэлт | Тоо, ширхэг | Нэгж үнэ /мян.төг/ | Нийт дүн /мян.төг/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сагсан бөмбөг иж бүрдэл | Самбар нь тэгш өнцөгтэй гадаргуутай, сайжруулсан хуванцар, бэхжүүлсэн хуванцар, бэхжүүлсэн шил, эсвэл шилэн хуванцар материалаар, гэрэл гялбахгүй байхаар хийгдсэн байна. Сагсан бөмбөгийн самбар хөдөлгөөнгүй бэхлэгдсэн байх бөгөөд түүний ирмэг нь хамгаалах бүхрхүүлтэй байна. сагсан бөмбөгийн самбарыг тулгуурт хамгаалах зөөлөвч хийнэ. Хэмжээ нь: L1800 x W1050 мм Самбарын зузаан 3-5 см байна. Цагираг нь 45 см диаметртэй байх ба материал нь төмөр, улбар шар буюу улаан өнгөтэй, тор тэгтоох нүхнүүдтэй, тортой, хүзүүвчиндээ пүрштэй, самбарт тогтоох нүхнүүд болон бсолттой байна. Хананы бэхэлгээтэй, хананд байрлах, хос самбар байна. Сагсны бөмбөг нь синтетик лидерин үнэргүй, гадаргуу нь оёдолгүй, наалттай, дотор хэсгээрээ резинэн эдлэлээр хийгдсэн, улбар шар өнгөтэй. Бөмбөгний диаметр 650 мм, 260 гр жинтэй, доторхи даралт нь 0.3-0.325 kgf/см. MNS664 (нэг иж бүрдэлд 3 ш бөмбөг) | 30 | 3,100.0 | 93,000.0 |
| 2 | Волейболын шон, торны комплекс | Волейболын шон нь доошоо 40 см орох суурьтай байх ба дугуй цилиндр хэлбэртэй төмөр, өндрийн түвшинг хялбар өөрчлөх боломж бүхий тор татах хос төхөөрөмж байна. Шонгийн өндөр нь шалны түвшнөөс дээш 2550 мм хүртэл сунах боломжтой торны өндрийг тааруулахын тулд 800 мм зайд дээш доош болгох хялбар механизмтай байна. Шонгийн суурь: Шонг шал буюу газарт бэхлэх ба төмөр олс, татуурга, хүндрүүлэгчгүйгээр тогтоож түүнийг зөөлөн материалаар бүрнэ. Шонг тогтоогоогүй үед нүхийг заавал таглана. Торыг хар өнгийн 0.3 мм хүртэл диаметртэй мяндсан, олсон утсаар шоо дөрвөлжин сүлжиж хийнэ. Шоо дөрвөлжин нүд нь 100мм x 100мм эсвэл 45мм x 45мм хэмжээтэй байж болно. Торны дээд хүрээг 70мм хүртэл, доод хүрээг 50мм хүртэл өргөнтэй цагаан өнгийн материалаар эмжиж хийнэ. Хэмжээ нь: L9500-10000мм x W1000мм. Өндөр хэмжигч нь цагаан өнгөтэй, сунадаг, дээрээ хэмжээстэй байх бөгөөд хөнгөн байна. Хязгаарлагч антен: Хуванцар уян хатан шинж бүхий торонд хялбар бэхлэх боломжтой урт нарийхан саваа хэлбэртэй байх ба торноос дээш агаарын орон зайд тоглолтын талбайг тодорхойлох чиг үүрэг бүхий хэрэглэл. Волейболын спортын орчин болон сургалтад тавих шаардлага. MNS 6642:2016 | 30 | 1,500.0 | 45,000.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Теннисний ширээ /тор, бөмбөг, ракет иж бүрэн/ | Төмөр хөлтэй, 9.5 см диаметртэй дугуйтай, эвхэгддэг /тавцанг өргөхөд буухаас хамгаалсан түгжээтэй/, ширээний тавцан нь сайн чанарын шахмал /100% полистер материалтай/ байна. Тор, бөмбөг, зориулалтын цохиур тус бүр 10 ширхэг байна. Хэмжээ: L2750 x W1500 x H760 мм, Тавцангийн зузаан нь 30 мм-ээс багагүй байна | 30 | 1,300.0 | 39,000.0 |
| 4 | Бие бялдрын иж бүрдэл | **Биеийн өндөр хэмжигч:** Зориулалтын биеийн өндөр хэмжигч байна. **Хананд тогтоосон метр:** Тоо бичсэн зурагтай өндөр хэмжигч байж бол-о. **Биеийн жин хэмжигч:** Зориулалтын биеийн жин хэмжигч шилэн электрон. **Туузан метр:** Зориулалтын гурван метр урттай сунаж агшдаггүй сайн чанарын материалтай байна. **Атгалтын хүчийг хэмжигч:** Гарын атгах хүчийг хэмжигч зориулалтын багаж байна. **Секундомер:** Зориулалтын хугацаа хэмжигч цаг. **Шүгэл:** Сайн чанарын төмөр материалтай, дуугаралт нь чихэнд чийгүй байх (5 ширхэг). | 62 | 680.0 | 42,160.0 |
| 5 | Харайлтын ямаа | Төмөр хөлтэй, өндөр, нам тохируулагчтай, хөлний доод хэсэгт резинтэй, дээд хэсэг нь зөөлөвч болон лидринээр бүрсэн, үнэргүй байна. Хэмжээ: L600 x W400 x H800-1000 мм | 30 | 400.0 | 12,000.0 |
| 6 | Заалны турник | Хананд байрлуулдаг, авирч гардаг, дүүжлэгддэг, төмөр<br>Хэмжээ: өндөр 2.2-2.5м, өргөн нь 2.3м | 30 | 1,100.0 | 33,000.0 |
| 7 | Бариултай морь /Модон морь/ | Их бие мод, дээд хэсэг нь зөөлөвчтэй арьсан бүрээстэй, тулгуур хөл төмөр, хөлний доод хэсэгт резинтэй, бариул хуванцар эсвэл модон, өндөр нам тохируулагчтай байна. Хэмжээ: 160 см x 35 см x 115 см, бариул нь хоорондоо 40-45 см, өндөр 12 см, диаметр 3.4 см | 30 | 610.0 | 18,300.0 |
| 8 | Гимнастикийн дамжуурга | Дамжуурга нь хоёр тулгуур төмөр хөлтэй, хөндлөнгөөс харахад бага зэрэг нуман хэлбэртэй, суурь хэлбэр нь өөрчлөгдөггүй, дасгалын явцад хөдөлгөөнгүй бат бөх, модон ба гадаргуу нь түлхэхэд зөөлөн, гишгэлтэнд хэт гулсахгүй, хэт зууралдахгүй арьсыг гэмтээж үрэхгүй зөөлөн шир байх ба дамжуурганы тулгуур хөл хамгаалалтын зөөлөвчтэй байна. Дамжуурганы урд талыг зөөлөн бүрсэн хэсгийн дээд ирмэг нь дамжуургын гадаргуугаас хатуу байж болохгүй. Бүх ил гарсан хэсгүүдийг, ялангуяа дамжуургын доогуурх эрэг боолтуудыг далдалсан байна. Хэмжээ: L5000 x W100 x H500мм | 30 | 580.0 | 17,400.0 |
| | **Нийт дүн** | | **272** | | **299,860.0** |

Хянасан:

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт

Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа

9020070363 СТС2147 9116621

Боловсруулсан:

Сургалтын байгууллагын хөгжил, орчин, хэрэглэгдэхүүний бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч Б.Бадамжав

Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ш.Энхтуул

Сургалтын байгууллага, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн Х.Энхбаяр

....................оОо....................................